

## **Залилан, авилга, хээл хахуулийн талаар өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх журам**

Энэхүү журмаар ХасБанкны ажилтан болон харилцагчийн гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийн хүрээнд ажилтантай холбоотой залилан, авилга, хээл хахуулийн асуудлыг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх, тайлагнах, арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулна.

ХасБанкны Хянан нийцүүлэлтийн алба нь аливаа хүлээн авсан гомдлыг Дотоод аудитын газарт (ДАГ) шилжүүлж, хянуулах эсэхийг тодорхойлно.

ДАГ-т шилжүүлсэн тохиолдолд нууцын зэрэглэлтэй мэдээлэлтэй танилцах эрхийг хяналт шалгалтын багт олгож, шалгалтын ажиллагааг бусад дотоод аудитын шалгалтын ажиллагаатай нэгэн адил явуулна. Залилан, авлига, хээл хахуулийн хэрэгт сэжиглэгдсэн этгээдээс байцаалт авч, шалгалтын багийн ахлагч болон бусад холбогдох этгээд(үүд)-ээр байцаалт авхуулна. Шалгаж буй асуудал нь Тэнгэр санхүүгийн нэгдэл болон ХасБанкны дотоод үйл ажиллагаанаас бусад этгээдийг хамарсан, эсвэл гэмт хэргийн шинжтэй байвал цагдаагийн байгууллага эсвэл бусад холбогдох байгууллагад шилжүүлнэ.

Хяналт шалгалтын баг нь шалгалтын явцад гаргасан аливаа дүгнэлт, холбогдох этгээдийн тайлбар, цуглуулсан бусад нотлох баримтад үндэслэн шалгалтын тайланг гаргана. Тайланг Ерөнхий аудитор хянаж, баталсны дараа холбогдох этгээдийн шууд удирдлага, Хүний нөөцийн удирдлагын хэлтэс болон Хуулийн хэлтэст тайлагнана. Харилцагч, гуравдагч этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн хүрээнд хандан, хаяглагдсан нэгжээс тухайн этгээдэд албан бичгээр хариу өгнө.

Шалгалтын явцад Банкны дотоод хяналтын үйл ажиллагааны процесс, мэдээллийн технологийн систем зэрэгт учирч болзошгүй эрсдэл илэрсэн тохиолдолд Хяналт шалгалтын баг Ерөнхий аудиторт мэдэгдэж, цаашид эрсдэлийг бууруулах зөвлөмж гаргана.

Залилан, авлига, хээл хахуулийн аливаа асуудлыг шийдвэрлэхэд эрсдэлийн ангилал тогтоож, тухайн ангилалд ногдох хариуцлагыг тухай бүр хүлээлгэнэ. Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зөрчилийг ХасБанкны "Зээлийн үйл ажиллагааны ерөнхий журам", зээлийн бус үйл ажиллагаатай холбоотой зөрчлийг ХасБанкны "Хөдөлмөрийн дотоод журам"-д үндэслэн ангилж, холбогдох хариуцлагыг хүлээлгэнэ. Ажилтан Банкнаас хүлээлгэсэн хариуцлагыг хүлээн зөвшөөрөхгүй бол Хөдөлмөрийн дотоод журмын дагуу гомдол гаргаж шийдвэрлүүлж болно.

Хяналт шалгалтын баг нь холбогдох систем, камерын бичлэг зэрэг шалгаж буй асуудалтай холбоотой бүхий л мэдээлэлтэй танилцах эрхтэй байна. Хяналт шалгалтын багийн цуглуулсан бүхий л материал, мэдээлэл нууцын зэрэглэлтэй байна. Шаардлагатай тохиолдолд Хяналт шалгалтын багийн гишүүдийн хувийн мэдээллийг нууцална.